



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд НААУ ОНӨ ХХК-ийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/02/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn Сайншанд сум 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Т.Оюунтуяа Утас: 99048991 Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.08.18 № 14/331

танай _____ -ны № _____ -т

ЗАМЫН ҮҮД НААҮ ОНӨ ХХК-ИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.МӨНХГЭРЭЛ ТАНАА

Татгалзсан дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Замын Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийхээр байсан.

Замын Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад дүгнэлт өгөхгүй. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

1. 2021 оны санхүүгийн тайланг аудитын байгууллагад хугацаандаа ирүүлээгүй, баталгаажуулаагүй, гарын үсэг зурагдаагүй, тайлан баланс тэнцээгүй, өнгөрсөн оны мөн үеийн мэдээлэлтэй зэрэгцүүлэгдээгүй, санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл өмнөх оны аудитлагдсан үлдэгдлээс зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, ...", Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх;" 5.1.5-д "хэмжигдэхүйц байх", 8.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 20 дугаар зүйлийн Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэгт заасан, 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", энэ хуулийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад "Аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын Санхүү тайлангийн зорилтын 2-т "Санхүүгийн тайланг

хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгжийн удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, ангилал, толилуулга, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Тайлант хугацааны эцэст хөрөнгийн тооллого хийх тушаал шийдвэр гараагүй, тооллого хийгдээгүй, авлага өр төлбөрийн тооцооны үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, авлага өр төлбөрийн журналаар үлдэгдэл санхүүгийн байдлын тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй, өр авлага “хасах” үлдэгдэлтэй ба цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн, харилцагчтай үүссэн тооцоог тухайн харилцагчийн нэрээр бус, өөрийн байгууллагын нэр болон ажилтны нэрээр бүртгэж, хяналт тавих боломжгүй болгож байгаа зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгт “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “ерөнхий нягтлан бодогч нь... дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог ... баталгаажуулах”, 20.2.6 “ерөнхий нягтлан бодогч нь ...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Бэлэн мөнгөний болон бараа материалын эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч хянаж баталгаажуулаагүй, кассын болон бараа материалын орлого, зарлагын падаан, шаардах хуудасны гарын үсгийн бүрдэл дутуу зэрэг нь нийтлэг, гарсан ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад.....шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно ...”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4. Замын-Үүд сумын ЗДТГ-аас 2021 онд нийт 895.4 сая төгрөгийн санхүүжилт Төрийн сангийн дансанд төвлөрүүлснээс Замын Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн ХААН банкны дансанд 685.5 сая төгрөгийг шилжүүлж, үлдэгдэл санхүүжилт болох 209.9 сая төгрөгөөс 100.0 сая төгрөгийг шатахууны зардалд, 38.8 сая төгрөгийг гэрэлтүүлгийн цахилгаанд, 47.0 сая төгрөгийг НДШ, ХХОАТ-ын өглөгт, 24.0 сая төгрөгийг бусад зардлаар гаргасан байна. Эдгээр үндсэн үйл ажиллагаатай хамаарал бүхий 209.9 сая төгрөгийн санхүүжилт, зардал, өр авлагын тооцоог Замын Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “үнэн зөв байх,” 5.1.5-д “хэмжигдэхүйц байх”, 5.1.6-д “зохицох”, 20 дугаар зүйлийн Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэгт заасан, 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, энэ хуулийн 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэсэн

заалтуудтай нийцэхгүй ба тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шаардлага хангахгүй, өөрийн байгууллагын нөхцөлд тохируулан хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9-д *"Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"* гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18.2-д *"Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана."* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

6. Тус байгууллагын захирал нь дотоод хяналт хариуцсан ажилтан томилоогүй, дотоод хяналтын журам боловсруулаагүй, байгууллагын үйл ажиллагаанд Удирдах зөвлөл нь хяналт тавиагүй зэрэг нь Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолын 1.3 -д *"Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"*-тай байна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 19 дүгээр зүйлийн 19.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно"*, *"Замын-Үүд НААҮ"ОНӨ ХХК-ийн дүрмийн Удирдах зөвлөлийн явуулах үйл ажиллагааны 6.31-д "Захирал болон компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавих"* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой байсан.

Гэвч, дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Замын-Үүд НААҮ ОНӨХХК нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын 1995 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 06 дугаар тушаалыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4-т “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг Дорноговь аймгийн Засаг даргын захирамжаар, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Дорноговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2004 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 12 дугаар тушаалаар томилсон.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 31.7 сая төгрөгийн худалдан авалтын 4 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 699.4 сая төгрөгийн орлогын 17 гүйлгээг мэдээлээгүй байна.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Жилийн эцсийн тооллогыг иж бүрэн хийж, үр дүнг хэлэлцэж шийдвэрлэсэн байдалд анхаарах
- Авлага өр төлбөрийн тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан эсэх
- ЗДТГ-аас олгогдож буй санхүүжилт, зарцуулалт бүртгэл тайланд бүрэн тусгагдсан эсэхэд хяналт тавих
- Компанийн автомашин, техник хэрэгслийн ашиглалт, авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын картын хөтлөлт, шатахуун зарцуулалт, нормд хяналт тавих

Тав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5 албан шаардлага хүргүүлж, 8 зөвлөмж өгсөн. Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал байхгүй.

Албан шаардлага

1. “Замын-Үүд НААҮ” ОНӨ ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг аудитын байгууллагад хугацаандаа ирүүлээгүй, баталгаажуулаагүй, гарын үсэг зурагдаагүй, тайлан баланс тэнцээгүй, өнгөрсөн оны мөн үеийн мэдээлэлтэй зэрэгцүүлэгдээгүй, санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл өмнөх оны аудитлагдсан үлдэгдлээс зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, ...”, Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-д “үнэн зөв байх;” 5.1.5-д “хэмжигдэхүйц байх”, 8.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна”, 20 дугаар зүйлийн Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэгт заасан, 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, энэ хуулийн 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад “Аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын Санхүү тайлангийн зорилтын 2-т “Санхүүгийн тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгжийн удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, ангилал, толилуулга, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

2. Тайлант хугацааны эцэст хөрөнгийн тооллого хийх тушаал шийдвэр гараагүй, тооллого хийгдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгт “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2-т “дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэж заасныг заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

3. Авлага өр төлбөрийн тооцооны үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “ерөнхий нягтлан бодогч нь... дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог ... баталгаажуулах”, 20.2.6 “ерөнхий нягтлан бодогч нь ...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. “Замын-Үүд НААҮ” ОНӨ ХХК Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 31.7 сая төгрөгийн худалдан авалтын 4 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 699.4 сая төгрөгийн орлогын 17 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-т Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6 дугаар зүйлийн 6.4.5-т “...орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр,...” тус тус мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

5. “Замын-Үүд НААҮ” ОНӨХХК нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1.8 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс албан шаардлага, зөвлөмж хэрэгжээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн бүртгэл, бодлоготой холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: “Замын-Үүд НААҮ” ОНӨХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг шаардлага хангахгүй, өөрийн байгууллагын нөхцөлд тохируулан боловсруулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9-д “ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг”, 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг боловсруулан, захирлаар батлуулж, мөрдөн ажиллах

2. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант хугацааны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулаагүй, биелэлт, үр дүнг тооцоогүй, үйл ажиллагааны тайлан ирүүлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2.2-т “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх”, Компанийн дүрмийн 4-т “... зорилтот түвшинг тодорхойлсон урт болон ойрын хугацааны үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг Удирдах зөвлөлөөр батлуулж ажиллана”, 31 дүгээр заалт Удирдах зөвлөл дараах үйл ажиллагаа явуулна: 31.а-д “Компанийн бизнес төлөвлөгөөг хянаж батлах” заалтуудтай нийцэхгүй байна.

2.1 Өгсөн зөвлөмж: Холбогдох хуулийн зүйл заалтыг мөрдөж ажиллах, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулах, биелэлт үр дүнг тооцож ажиллах.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий журнал, тусгай журналд давхар бичилт хийгддэг ч бичилтүүд хангалттай баримтаар дэмжигдээгүй, журнал бичилтүүд зөв дансууд руу бичигдсэн эсэхэд нягтлан бодогч сар, улирал бүр хянаагүй, аливаа зөрүүнүүдийг зохих байдлаар шийдвэрлээгүй, мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгө, орлого зардлын дансдыг тулган баталгаажуулдаггүйгээс гарсан алдаа, зөрүүг илрүүлэх, тухай бүрд нь шийдвэрлэх боломж бүрдээгүй, жилийн эцэст бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгдээгүй нь хөрөнгө бодитоор байгаа эсэх, дутагдсан эсэхийг тодорхойлох боломжгүй болгосон, 2 нярав ажлаас чөлөөлөгдөхөд тооцоо тооллого хийгдээгүй, ажил хүлээлцээгүй, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэнгүй, дотоод хяналтын журам боловсруулаагүй, байгууллагын үйл ажиллагаанд Удирдах зөвлөл нь хяналт тавиагүй зэрэг нь Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолын 1.3 -д “Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-тай байна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д

“Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, “Замын-Үүд НААҮ” ОНӨХХК-ийн дүрмийн Удирдах зөвлөлийн явуулах үйл ажиллагааны 6.31.Д-д “Захирал болон компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавих” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын журам боловсруулж, хяналтын тогтолцоог зохих түвшинд зохион байгуулах. Хяналтын үйл ажиллагааг тодорхой давтамжтайгаар /сар бүр, тайлант хугацааны эцсийн байдлаар гэх мэт/ үр дүнтэй хэрэгжүүлж байх.

4. Авлага, өр төлбөрийн тооцоотой холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Авлага өр төлбөрийн журналаарх үлдэгдэл санхүүгийн байдлын тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй, өр авлага “хасах” үлдэгдэлтэй ба цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн, харилцагчтай үүссэн тооцоог тухайн харилцагчийн нэрээр бус, өөрийн байгууллагын нэр болон ажилтны нэрээр бүртгэж, хяналт тавих боломжгүй болгож байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “ерөнхий нягтлан бодогч нь... дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог ... баталгаажуулах”, 20.2.6 “ерөнхий нягтлан бодогч нь ...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээ гарсан тухай бүрд нь харилцагч бүрээр тооцоо үүсгэн бүртгэх, өр авлагын хасах үлдэгдлийг тухай бүр хянах, НББ-ийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг мөрдөж ажиллах.

5. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт: Бэлэн мөнгөний болон бараа материалын эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч хянаж баталгаажуулаагүй, кассын болон бараа материалын орлого, зарлагын падаан, шаардах хуудасны гарын үсгийн бүрдэл дутуу, гарсан ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад.....шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно ...”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж: Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч хянаж баталгаажуулах, хүчин төгөлдөр /ибаримт/ анхан шатны баримтаар ажил гүйлгээг бүртгэж, тайландаа тусгах.

6. Үйл ажиллагааны орлого зардалтай холбоотой асуудал

6.1 Илрүүлэлт: Замын-Үүд сумын ЗДТГ-аас 2021 онд нийт 895.4 сая төгрөгийн санхүүжилт Төрийн сангийн дансанд төвлөрүүлснээс Замын Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн ХААН банкны дансанд 685.5 сая төгрөгийг шилжүүлж, үлдэгдэл санхүүжилт болох 209.9 сая төгрөгөөс 100.0 сая төгрөгийг шатахууны зардалд, 38.8 сая төгрөгийг гэрэлтүүлгийн цахилгаанд, 47.0 сая төгрөгийг НДШ, ХХОАТ-ын өглөгт, 24.0 сая төгрөгийг бусад зардлаар гаргасан байна. Эдгээр үндсэн үйл ажиллагаатай хамаарал бүхий 209.9 сая төгрөгийн санхүүжилт, зардал, өр авлагын тооцоог Замын Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “үнэн зөв байх,” 5.1.5-д “хэмжигдэхүйц байх”, 5.1.6-д “зохицох”, 20 дугаар зүйлийн Ерөнхий нягтлан

бодогчийн эрх, үүрэгт заасан, 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, энэ хуулийн 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6.2 Өгсөн зөвлөмж: Үндсэн үйл ажиллагаатай хамаарал бүхий орлого зардлын гүйлгээг бүртгэл тайландаа бүрэн тусгах, холбогдох стандарт, хуулийн зүйл заалтыг мөрдөж ажиллах.

7. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх асуудал

7.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайлан дахь орон нутгийн өмчийн дүн нь улсын бүртгэлийн гэрчилгээний дүнгээс 4,100.0 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-д “Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг тухайн шийдвэр гарснаас хойш ажлын 15 өдрийн дотор хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

7.2 Өгсөн зөвлөмж: Компанийн тухай хуулийн дагуу орон нутгийн өмчид гарсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, баталгаажуулах

8. Мөнгөн гүйлгээний данстай холбоотой асуудал:

8.1 Илрүүлэлт: “Замын-Үүд НААҮ” ОНӨХХК нь 2021 онд тушаал шийдвэргүйгээр 10.2 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг цахилгаанчин ажилтай Байгалмаа овогтой Бямба-Очирт олгосон ба 2020 онд үйлдвэрлэлийн осолд орж, хөдөлмөрийн чадвараа алдсан, тухайн ондоо тушаал шийдвэр гарсан гэх ч өглөгийг бүртгээгүй, холбогдох бичиг баримтын бүрдэл хангаагүй, компанийн удирдах зөвлөлийн шийдвэр гараагүй байна.

Энэ нь Дорноговь аймгийн Засаг даргын 2004 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 27 тоот захирамжаар баталсан “Замын-Үүд Нийтийн аж ахуй үйлчилгээ” ОНӨ ХХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн Компанийн удирдах зөвлөл, түүний эрх хэмжээний хүрээнд 31-ийн г-д заасан “Компанийн өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх хэмжээг тогтоож өгөх”, 7 дугаар бүлгийн 41 дүгээр заалтад заасан “Захирал нь компанийн үйл ажиллагаатай холбоотой 3 сая төгрөгөөс дээшгүй гэрээ хэлэлцээр хийнэ.”, 43.3-д заасан Захирлын эдлэх эрх, хүлээх хариуцлагын хэмжээ хязгаар,“Компанийн нэрийн өмнөөс эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

8.2 Өгсөн зөвлөмж: Компанийн дүрмийг дагаж мөрдөн, Удирдах зөвлөлийн холбогдох шийдвэр гарсны дараа хөрөнгө захиран зарцуулах.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	+	+						+
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	13						5		8	
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	13						5		8	